



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 1704

Шивээговь сум

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний өрөөг тохижуулах ажлын гүйцэтгэлийг хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний өрөөг тохижуулах” ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

- | | |
|-----------------------|---|
| Комиссын дарга: | Ч.Сугармаа
(Засаг даргын орлогч) |
| Гишүүд: | Б.Алтансүх
(Нийгмийн бодлогын мэргэжилтэн) |
| | З.Гантуяа
(Соёлын төвийн үйлчлэгч) |
| | Ж.Наранцацрал
(2 дугаар багийн иргэн) |
| Нарийн бичгийн дарга: | Ц.Замбага
(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн) |

2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний өрөөг тохижуулах ажилд хийгдсэн засвар үйлчилгээ болон бараа, тоног төхөөрөмжийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зөвлөлийн хөрөнгөнд бүртгэж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргүүн (А.Эрдэнэчулуун)-д үүрэг болгосугай.

3.Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн засвар үйлчилгээ болон тоног төхөөрөмжийн үзүүлэлтэд акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ

